

*Санхүүгийн зохицуулах хороо*

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ОРОЛЦОГЧИД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ  
БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.8 дахь заалтад тусгагдсан үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээд (цаашид “хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд” гэх)-ийг бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны тавьсан шаардлагыг хангаж хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь энэхүү журамд тавигдсан шаардлагыг биелүүлж ажиллах, хуульчдын талаарх өөрчлөлтийг тухай бүр Хороонд ирүүлэх үүрэгтэй.

**Хоёр. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага**

2.1. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааг 3-аас доошгүй сар эрхэлсэн байх;

2.1.2. Хорооноос зөвшөөрсөн байгууллагаас зохион байгуулсан үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан 2 ба түүнээс дээш орон тооны хуульчтай байх;

2.1.3. Хуульчид нь тухайн хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд 3 сараас доошгүй хугацаанд ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх;

2.1.4. Хуульчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй талаар Хуульчдын холбооноос тодорхойлолт гаргуулсан байх;

2.1.6. Хууль тогтоомжид заасан бусад.

**Гурав. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичиг**

3.1 Энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь Хороонд бүртгүүлэх хүсэлтээ дор дурдсан баримт бичгийн хамт ирүүлнэ:

3.1.1 Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /журмын 1-р хавсралт маягт/;

3.1.2. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, холбогдох тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

3.1.3. Орон тооны хуульчдын хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийн хуулбар;

3.1.4.Хуульчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай тодорхойлолт;

3.1.5. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааны журам;

3.1.6.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаарх түүхчилсэн дэлгэрэнгүй танилцуулга.

### **Дөрөв. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах**

4.1. Хороо хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн ирүүлсэн баримт бичгийг хүлээн авсанаас хойш ажлын 20 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

4.2. Хороо хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шаардлага хангасан гэж үзвэл хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэнэ.

4.3. Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд хүсэлт гаргасан этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

4.4.Хороонд бүртгэгдсэн хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг дор дурдсан шалтгаанаар бүртгэлээс хасна:

4.4.1. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд өөрөө хүсэлт гаргасан;

4.4.2 Энэхүү журмын 3.1.1-3.1.4-т заасан шаардлагуудын аль нэгийг болон бүгдийг хангахгүй болсон;

4.4.3.Бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.4.4.Бодит бус дүгнэлт гаргасан, дагаж мөрдвөл зохих хууль, дүрэм, журам, стандартыг зөрчсөн, мэргэжлийн ноцтой алдаа гаргасан, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүссэн;

4.4.5 Хороо ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

4.4.6. Холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон.

4.5. Энэхүү журмын 4.4.2-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан этгээд бүртгэлээс хасагдсанаас хойш 3 жилийн хугацаанд Хороонд дахин бүртгүүлэхээр хандах эрхгүй.

4.6. Бүртгүүлэхээр хүсэлт гаргасан болон бүртгэлтэй хуулийн этгээд энэхүү журмын 4.5-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдэд ажиллаж байсан зохих мэргэжлийн болон

хууль хяналтын байгууллагас буруутай нь тогтоогдсон хуульчдыг 3 жилийн хугацаагаар авч ажиллуулахыг хориглоно.

4.7. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд бүртгэсэн, бүртгэлээс хассан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.

4.8. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэсэн, бүртгэлээс хассан тухай шийдвэрийг Хороо ажлын 10 хоногт багтаан үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч, олон нийтэд цахим сүлжээгээр мэдээлнэ.

#### **Тав. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн төрөлжсөн сургалт**

5.1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтыг Хорооноос зөвшөөрсөн байгууллага зохион байгуулна.

5.2. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдүүд нь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад 3 жил тутам хамрагдаж, зохих шалгалт өгч гэрчилгээ авсан байна.

#### **Зургаа. Хуулийн дүгнэлт, түүний хяналт**

6.1. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хууль зүйн үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам заавар арга, аргачлалыг мөрдөнө.

6.2. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зах зээлд оролцогчид хуулийн болон бусад үйл ажиллагааны талаар гаргасан тайлан дүгнэлтийг Хороонд хүргүүлнэ.

6.3. Хороо бүртгэлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж, шалгалт хийнэ.

#### **Долоо. Хариуцлага**

7.1. Хороо энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад нь мэдэгдэх, хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд мэдэгдэнэ.

7.2. Бүртгэлтэй хуулийн этгээдийн аливаа хууль зөрчсөн үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Хороо хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.

---000---

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 1 дүгээр хавсралт

### БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо : .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IV байр

Бага тойруу -3

Улаанбаатар -15160

Монгол улс.

Хэнээс: .....

.....

.....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, байгууллагын хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

.....

/Хуулийн байгууллагын нэр ХК, ХХК, ЗБН, ББН, ХХН/

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь  (мянган .төгрөгөөр)

Байгууллагын гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь /гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Мэргэжлийн байгууллагад эрхлэх албан тушаал

Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх үнэлгээчид нь дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар

Бүртгүүлэхээр хүргүүлсэн баримтыг Санхүүгийн зохицуулах хорооны 201 оны ... дугаар сарын ...-ний өдрийн .. дүгээр тогтоолоор батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зах зээлд оролцогчидхууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зах зээлд оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргах этгээдээр бүртгэн авна уу.

Бид үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:**

/...../  
/гарын үсэг/

/...../  
/овог, нэр /

/...../

/ албан тушаал /

/тамга тэмдэг/